



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СБА-2023/176/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Баруун-Урт сум

2023 он

Дарга,
тэргүүлэх аудитор: М.Нарантуяа
Утас: 70518396
Аудитын менежер: Г.Даваа
Утас: 70512123
Ахлах аудитор: Ө.Золзаяа
Утас: 70512123

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

| | |
|---|----|
| 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ | 3 |
| 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ | 5 |
| 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА | 8 |
| 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа | 8 |
| 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин | 8 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 8 |
| 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд..... | 9 |
| 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 9 |
| 4. АУДИТЫН ТАЙЛАН | 11 |
| 4.1 Ерөнхий зүйл | 11 |
| 4.2 Материаллаг байдал | 11 |
| 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 12 |
| 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 12 |
| 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 12 |
| 4.5.1 Завсрын аудитын талаар..... | 12 |
| 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ | 12 |
| 5.1 Албан шаардлага..... | 13 |
| 5.2 Зөвлөмж..... | 13 |
| 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ | 14 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ХЭДС | Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих Сан |
| ХХҮЕГ | Хөдөлмөр Халамж Үйлчилгээний Ерөнхий газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| УТХО | Улсын Төсвийн Хөрөнгө Оруулалт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани |

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

22000 Баруун-Урт сум, Сүхбаатар аймаг
Утас: 70518396, Факс: 70518396
E-mail: Sukhbaatar@audit.gov.mn

2022.08.24 № 67
танай _____-ны № _____-т

СҮХБААТАР АЙМГИЙН ХӨДӨЛМӨР
ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН
ДАРГА Д.ГЭРЭЛБАДРАХ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагааны тасралтгүй байх зарчим, холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээний анхаарал татсан асуудал болон санхүүгийн тайлангийн хойших үйл явдал, бусад асуудлын талаар тодорхойгүй байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1 дүгээр тогтоолоор 2022-2023 оны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 7 хөтөлбөрийг баталсан байна.

Бусад асуудлын хэсэг

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн иргэд, аж ахуй нэгжид олгосон санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн тайлант оны гүйцэтгэл 328,877.6 мянган төгрөг буюу 44.4 хувь байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

D:/Bichig hereg/2023/A4 toot

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.НАРАНТУЯА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|--|--------------------|----------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 959,053,512 | 1,467,078,162 |
| 33 | АВЛАГА | 959,053,512 | 1,467,078,162 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 12,486,700 | 12,149,000 |
| 335 | Бусад авлага | 946,566,812 | 1,454,929,162 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | - | 9,240,000 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 946,566,812 | 1,445,689,162 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 959,053,512 | 1,467,078,162 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 959,053,512 | 1,467,078,162 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 959,053,512 | 1,467,078,162 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 959,053,512 | 1,467,078,162 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,226,861,020 | 959,053,512 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (267,807,508) | 508,024,650 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 959,053,512 | 1,467,078,162 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|---------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 663,547,826 | 1,411,878,000 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 81,355,226 | 37,800,000 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 81,355,226 | 37,800,000 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 81,355,226 | 37,800,000 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 81,355,226 | 37,800,000 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 582,192,600 | 1,374,078,000 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 582,192,600 | 1,374,078,000 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 28,935,350 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,650,250 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 542,607,000 | 1,374,078,000 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 918,555,334 | 903,853,350 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 918,555,334 | 903,853,350 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,635,600 | 4,073,000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,850,000 | 4,073,000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,850,000 | 4,073,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,785,600 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,785,600 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 888,919,734 | 899,780,350 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 226,307,117 | 429,347,962 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 226,307,117 | 429,347,962 |

| | | | |
|--------|--|----------------------|--------------------|
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 81,355,226 | 112,657,038 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 81,355,226 | 112,657,038 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 28,560,000 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 28,560,000 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 581,257,391 | 329,215,350 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 581,257,391 | 329,215,350 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>(255,007,508)</u> | <u>508,024,650</u> |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>(255,007,508)</u> | <u>508,024,650</u> |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>663,547,826</u> | <u>1,424,364,700</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 81,355,226 | 50,286,700 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 81,355,226 | 50,286,700 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 81,355,226 | 50,286,700 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 81,355,226 | 37,800,000 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | 12,486,700 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 582,192,600 | 1,374,078,000 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 582,192,600 | 1,374,078,000 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 28,935,350 | - |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 10,650,250 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 542,607,000 | 1,374,078,000 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>1,211,383,434</u> | <u>1,753,242,350</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,211,383,434 | 1,753,242,350 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 29,635,600 | 4,073,000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 2,850,000 | 4,073,000 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,850,000 | 4,073,000 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,785,600 | - |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,785,600 | - |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,181,747,834 | 1,749,169,350 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 506,648,517 | 1,257,347,962 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 506,648,517 | 1,257,347,962 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 93,841,926 | 112,657,038 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 93,841,926 | 112,657,038 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | - | 49,949,000 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 49,949,000 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 581,257,391 | 329,215,350 |

| | | | |
|----------|---|-----------------------------|-----------------------------|
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 581,257,391 | 329,215,350 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>(547,835,608)</u> | <u>(328,877,650)</u> |
| 14 | Бусад эх үүсвэр | 560,635,608 | 328,877,650 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 560,635,608 | 328,877,650 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>560,635,608</u> | <u>328,877,650</u> |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|----------------------|-------------|---|
| C01 | 2016 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 959,053,512 | 0.00 | 959,053,512 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 959,053,512 | 0.00 | 959,053,512 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | | | - |
| C08 | 2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 959,053,512 | 0.00 | 959,053,512 |
| D01 | 2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 959,053,512 | 0.00 | 959,053,512 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 0.00 | 0.00 | - | 0.00 | - |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 0.00 | 0.00 | 959,053,512 | 0.00 | 959,053,512 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | - | 0.00 | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 0.00 | 0.00 | - | 0.00 | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 0.00 | 0.00 | - | 0.00 | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 0.00 | 0.00 | - | 0.00 | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 0.00 | 508,024,650 | 0.00 | 508,024,650 |
| D09 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 0.00 | 0.00 | 1,467,078,162 | 0.00 | 1,467,078,162 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Хөтөлбөр, төслийн ангилал | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---------------------------|---|------------------|------------------|----------------|
| Код | Үзүүлэлт | | | |
| 11 | ОРЛОГЫН НИЙТ ДҮН | 1,374,078,000.00 | 1,261,420,934.60 | 112,657,065.40 |
| 112 | ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт | 1,374,078,000.00 | 1,261,420,934.60 | 112,657,065.40 |
| 1121 | ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт | 1,374,078,000.00 | 1,261,420,934.60 | 112,657,065.40 |
| 2 | ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН | 1,374,078,000.00 | 1,261,420,934.60 | 112,657,065.40 |
| 21 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээ хангах үйлчилгээ | 9,240,000.00 | 9,230,000.00 | 10,000.00 |
| 22 | Ажилд зуучлах үйлчилгээ | 4,760,000.00 | 3,913,066.60 | 846,933.40 |
| 23 | Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох хөтөлбөр | 24,340,000.00 | 22,775,900.00 | 1,564,100.00 |

| | | | | |
|-----|---|----------------|----------------|---------------|
| 24 | Ажлын байрыг дэмжих хөтөлбөр | 370,120,000.00 | 326,712,000.00 | 43,408,000.00 |
| 25 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр | 48,096,000.00 | 27,298,255.00 | 20,797,745.00 |
| 26 | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 379,732,000.00 | 361,156,400.00 | 18,575,600.00 |
| 27 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөр | 187,984,000.00 | 130,416,700.00 | 57,567,300.00 |
| 280 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөр | 122,800,000.00 | 122,350,000.00 | 450,000.00 |
| 281 | Ногоон ажлын байр хөтөлбөр | 200,000,000.00 | 188,888,100.00 | 11,111,900.00 |
| 282 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 25,016,000.00 | 22,685,300.00 | 2,330,700.00 |
| 32 | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл | 4,500,000.00 | 4,073,000.00 | 427,000.00 |
| 33 | Хөдөлмөрийн тухай хуулийн /шинэчилсэн найруулга/ болон ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах | 5,000,000.00 | 4,882,500.00 | 117,500.00 |
| 34 | Бүртгэл мэдээллийн сүлжээ ажиллуулах | 2,000,000.00 | 1,977,000.00 | 23,000.00 |
| 35 | Хөдөлмөрийн салбарын ажилтнууд, ХНЗ-ийн 3-н талт хорооны төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хийгдэх чадавх бэхжүүлэх сургалт | 10,000,000.00 | 9,925,900.00 | 74,100.00 |
| 36 | Сурталчилгаа, олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах | 7,500,000.00 | 7,475,040.00 | 24,960.00 |
| 37 | Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ | 14,000,000.00 | 13,986,800.00 | 13,200.00 |
| 39 | Гарын авлага хэвлэмэл материал | 4,000,000.00 | 3,675,000.00 | 325,000.00 |

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь “Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, нийгмийн халамжийн үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэх замаар нийгмийн тогтвортой хөгжлийг хангах” эрхэм зорилгын хүрээнд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны хөтөлбөрийг хэрэгжүүлж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө дунд зэрэг байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 508,024.6 мянган төгрөгөөр буюу 53 хувиар нэмэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

| Үзүүлэлт | Б | /мянган төгрөгөөр/ | | |
|--|---|--------------------|--------------------|------------------|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
| | | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | - | - | - |
| Авлага | | 959,053.5 | 1,467,078.2 | 508,024.7 |
| Бараа материал | | - | - | - |
| Үндсэн хөрөнгө | | - | - | - |
| Нийт хөрөнгө | | 959,053.5 | 1,467,078.2 | 508,024.7 |
| Өр төлбөр | | - | - | - |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | | 959,053.5 | 1,467,078.2 | 508,024.7 |
| Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн | | 959,053.5 | 1,467,078.2 | 508,024.7 |

- Авлага данс. Тухайн данс өмнөх онтой харьцуулахад 53 хувиар нэмэгдсэн ба ХЭДС-ийн хөтөлбөрт хамрагдсан аж ахуй нэгж, байгууллага, иргэнд 828,000.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлсэн, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөр 9,240.0 мянга, татаас санхүүжилтийн авлага 12,149.0 нийт 849,389.0 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт 328,877.6 мянга, татаас санхүүжилтийн 12,486.7 мянга нийт 341,364.3 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,374,078.0 мянган төгрөгөөр төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвөөс санхүүжих эх үүсвэр 1,374,078.0 мянган төгрөг батлагдсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийн дэмжих сангийн санхүүгийн эргэн төлөлтийг 7 хөтөлбөрийн хүрээнд 740,773.7 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүй төлбөрийн орлогыг 25,000.0 мянган төгрөгөөр төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр төсөл, хөтөлбөрийн эргэн төлөлт 328,877.6 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр 37,800.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, дээд шатны байгууллагад 354,528.6 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт гүйцэтгэл 399,096.1 мянган төгрөг буюу 47.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

| /мянган төгрөгөөр/ | | | | | |
|--------------------|---|------------|-----------|------------|---------|
| № | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
| 1 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | 301,072.7 | 153,986.0 | 147,086.7 | 51.1 |
| 2 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 55,616.5 | 27,511.8 | 28,104.7 | 49.5 |
| 3 | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 101,263.2 | 59,750.0 | 41,513.2 | 59.0 |
| 4 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 37,281.7 | 29,159.9 | 8,121.8 | 78.2 |
| 5 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | 137,907.2 | 40,800.0 | 97,107.2 | 29.6 |
| 6 | Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл | 107,332.5 | 17,370.0 | 89,962.5 | 16.2 |
| 7 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 300.0 | 300.0 | - | 100.0 |
| 8 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөр | 25,000.0 | 37,800.0 | (12,800.0) | 151.2 |
| НИЙТ | | 765,773.7 | 366,677.7 | 399,096.1 | 47.9 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээнд 1,369,578.0 мянга, хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн урамшуулал, үйл ажиллагааны зардалд 4,500.0 мянга нийт 1,374,078.0 төгрөгийн орлого төвлөрч гүйцэтгэлээр 1,261,420.9 мянган төгрөгийг зарцуулж 112,657.1 мянган төгрөгийг дээд шатны төсөвт төвлөрүүлсэн.

Нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалтыг авч үзвэл хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн зардалд 4,073.0 мянга, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг дэмжихэд 130,417.7 мянга, аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн зардалд 687,868.4 мянга, Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд 27,298.2 мянга, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 122,350.0 мянга, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөхөд 9,230.0 мянга, ажилд зуучлахад 3,913.1 мянга, Засгийн газар, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үндэсний зөвлөлийн тодорхойлсон хөтөлбөр, төсөлд 253,495.6 мянга, хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөрт 22,775.9 мянган төгрөгийг тус тус зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2022 оны 02 дугаар сарын 11-ний өдрийн 1 дугаар тогтоолоор хөдөлмөр эрхлэлтийг дэмжих 2022-2023 оны 7 хөтөлбөрийг баталсан байна. Үүнд:

- Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр
- Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр
- Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих хөтөлбөр
- Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр
- Ногоон ажлын байр хөтөлбөр
- Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжин сангаас гүйцэтгэлээр төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэг, зөвлөгөө өгөх, ур чадвар олгох сургалтад хамруулах болон хөдөлмөр эрхлэлтийн аймгийн зөвлөлийн урамшуулал хяналтын үйл ажиллагаанд нийт 1,261,420.9 мянган төгрөг зарцуулж, давхардсан тоогоор 3,190 хүн хамруулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ө.Золзаяа, гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Г.Даваа, дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 1/35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нийт хөрөнгийн 959,053.5 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 19,181.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тайлант онд 127 мэдээлэл оруулснаас 10 мэдээг хугацаа хоцроосон байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах зөвлөмж өгсөн.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сүхбаатар аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд завсрын аудит хийгээгүй.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

Хүснэгт 3 Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | /мянган төгрөгөөр/ Биелэлт | | |
|---------------|------------------------|----------|-------------------------------|----------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Төлбөрийн акт | 1 | 2,052.5 | 1 | 2,045.5 | 100 |
| Зөвлөмж | 4 | 40,575.0 | 4 | 40,575.0 | 100 |
| Нийт дүн | 5 | 42,627.5 | 5 | 42,627.5 | 100 |

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 176,344.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 111,703.6 мянган төгрөгийн зөрчилд зөрчилд¹ албан шаардлага хүргүүлж, бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой болон бусад 64,641.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгөв.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1 Албан шаардлага

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас авсан санхүүгийн дэмжлэгт хамрагдаж гэрээний хугацаа дуусгавар болсон 49 иргэн 111,703.6 мянган төгрөгийн эргэн төлөлтийг төлж, барагдуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1², 16 дугаар зүйлийн 16.5.5³, 41 дүгээр зүйлийн 41.2.3⁴, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3⁵ дахь заалтуудыг тус тус зөрчсөн байна.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Бараа материалын бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн программд 21,486.4 мянган төгрөгийн бараа материалыг улирлын нийт дүнгээр орлого авч, зарлагдсан нь ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл тодруулгын иж бүрэн байх, тасалбар болголт батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын баталсан бараа материалын тайлан, орлого зарлагын гүйлгээг гарсан тухайн үе бүрд хөтлөх, батламж мэдэгдлийн хүрээнд толилуулах

2. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: ХЭДС-аас санхүүгийн дэмжлэгт хамрагдаж гэрээний хугацаа дуусгавар болсон иргэдийн 41,854.9 мянга /хаяг тодорхойгүй, холбогдох боломжгүй 18 иргэний 40,675.0 мянга, эргэн төлөлтийг дахин тулгаж, тооцоо нийлэх 5 иргэний 1,179.9 мянга/-н төгрөгийн эргэн төлөлтийн үлдэгдэлтэй байна.

Өгсөн зөвлөмж: Иргэний хэргийн анхан шатны шүүхэд холбогдох иргэдийг эрэн сурвалжлуулах хүсэлт гаргах, эргэн төлөлтийг баримтаар давтан тулгаж, холбогдох иргэдтэй тооцоо нийлэх

3. Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Эм Эл Цахиурт Овоо ХХК-ын 1,300.0 мянган төгрөгийн хандив, тусламжийг 2021 оны санхүүгийн тайланд орлогоор илэрхийлэлгүй, үйлчлэгч И.Төмөрчөдөрийн хувийн харилцах дансаар дамжуулан авч, төсвөөс гадуур зарцуулалт хийгдсэн байна.

Өгсөн зөвлөмж: Хандив, тусламжийн асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчаараа дамжуулан шийдвэрлүүлж, хуулийн хүрээнд зарцуулалтыг тайлагнаж байх

4. Шилэн дансны хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн сайтад тайлант хугацаанд оруулах мэдээллээс 10 мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроож мэдээлсэн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв байршуулж, олон нийтийг мэдээллээр хангах;

² төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

³ батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

⁴ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁵ хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 06 дугаар сарын 30 - ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

| Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл | | | | | | | | | | | | |
|--|-------------|------------------|---------------|----------|-----------------|------------------|----------|-----------------|--------------------------------------|---------------------|---|----------|
| /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | | | |
| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хууль, журмыг хэрэгжүүлээгүй | 4 | 176,344.9 | - | - | 1 | 111,703.6 | 3 | 64,641.3 | - | - | - | - |
| Дүн | 4 | 176,344.9 | - | - | 1 | 111,703.6 | 3 | 64,641.3 | - | - | - | - |

| Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | | | | | | | | | | |
|---|-------------|----------|---------------|-----|-----------------|-----|---------|-----|----------|----------|
| /мянган төгрөгөөр/ | | | | | | | | | | |
| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | | |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | | |
| <i>www.shilendans.gov.mn цахим хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн</i> | 1 | 0 | | | | | | | 1 | 0 |
| Дүн | 1 | 0 | | | | | | | 1 | 0 |